ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ
ХҮНСНИЙ ТЕХНОЛОГИЙН ТЭНХИМ

ДАДЛАГЫН ТАЙЛАН БИЧИХ АРГАЧЛАЛ

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

НЭГ. ДАДЛАГЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Оюутан танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадварыг практик үйл ажиллагаатай холбон бататган гүнзгийрүүлж, ажиглалт, судалгаа, боловсруулалт хийх замаар хүнсний салбарт тавигдаж буй зорилт, тулгамдсан асуудлын талаар тодорхой мэдээлэл авах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцох, удирдахад шаардлагатай ур чадваруудыг эзэмших зорилготой үйлдвэрлэл дээр суралцах үйл ажиллагааг дадлага гэнэ.

Оюутан суралцах хугацаандаа мэргэжлийн онцлогоос хамааран 2-3 удаа дадлага хийнэ. Дадлагыг дотор нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- Танилцах дадлага
- Үйлдвэрлэлийн дадлага
- Эрүүл ахуйн мэргэжлийн дадлага
- Төгсөлтийн өмнөх дадлага

Танилцах дадлага

Тухайн мэргэжлийн талаар баримжаа авах улмаар хүнс болон хоол үйлдвэрлэлийн газрын бүтэц зохион байгуулалт, онцлог шинж, үйл ажиллагаатай танилцах зорилготой хийгдэнэ. Энэ дадлагыг хичээлийн үеэр хийх ба багш үйлдвэр аж ахуйн байгууллагаар дагуулан явж, нэг бүрчлэн тайлбарлан таниулна. Дадлагын төгсгөлд мэргэжлийн баримжаатай болсноор мэргэжилдээ дур сонирхолтой болж, цаашид үргэлжлүүлэн идэвхтэй суралцах үүд хаалга нээгдэнэ.

Үйлдвэрлэлийн дадлага

Энэ дадлагаар танхимд эзэмшсэн онолын мэдлэгт тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаатай биечлэн

танилцаж, түүхий эд хүлээн авахаас эхлэн бэлэн бүтээгдэхүүн гаргах хүртэлх технологийн ажиллагааг танин мэдэх, тоног төхөөрөмжийг ажиллуулах дадлага туршлагатай болно. Мөн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнд хийгдэх чанарын шинжилгээний арга зүйтэй танилцана.

Эрүүл ахуйн мэргэжлийн дадлага

Хүнсний үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйн мэргэжлээр суралцагч оюутан нь мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, хүнсний чанар, аюулгүй байдалд хяналт тавих арга зүйд суралцана.

Төгсөлтийн өмнөх дадлага

Энэ дадлагаар төгсөх ангийн о юутнууд сургалтын явцад үз эж судалсан онол арга зүйн мэ длэгээ ашиглан үйлдв эрлэлийн технологийг удирдах, эрүүл ахуйн хяналтыг зохион байгуулах, шинжилгээний үр дүнд боловсруулалт хийх, технологийн процессын хяналтын үүрэг функцтэй нарийвчлан танилцаж , хяналтын удирдамж , төлөвлөгөө боловсруулах удирдах үйл явц, судалгаа шинжилгээний ажлын арга барил эзэмших, төсөл зохиож хэрэгжүүлэх, маркетингийн судалгаанд боловсруулалт хийх үйл явцыг биеэр гүйцэтгэн мэргэжлийн дадлага, туршлага, арга зүй эзэмших зорилготой.

Энэ дадлагын үеэр тухайн үйлдвэр аж ахуйн нэгж байгуулагын технологийн процесс , түүнд мөрдөгдөх горим болон технологийн удирдлагын үйл ажиллагаатай танилцсанаар цаашид өөрийн ажиллах чигл элийг тогтоох, удирдах ажлын ур чадвар эзэмших, дипломын төсөл гүйцэтгэхэд тус дөхөм болох учиртай.

ХОЁР. ДАДЛАГЫН ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Дадлагыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэх бөгөөд тайланд ном, сурах бичиг, заавар, журам, стандарт зэрэг материалыг хуулбарлах биш, харин аль болох шинэ материал, технологи ашиглан өөрийн санал дүгнэлтийг тусгана.

Тайланг бичихдээ А4 хэмжээний цаасан дээр зүүн талд нь 25 мм, дээд болон доод талаас нь 20 мм хэмжээтэй зайтайгаар Arial-аар шивж хуудсыг дугаарласан байна. Мөн мөр хоорондын хэмжээ 1,0 ба үсгийн хэмжээ 12 байх ба 20-оос доошгүй хуудастай байна.

Ажлын ерөнхий төлөвлөгөөнд гүйцэтгэх ажлын ерөнхий агуулгыг багтаасан байна. Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө нь ерөнхий төлөвлөгөөний үндсэн дээр хийгдэх оюутны гүйцэтгэх ажлуудын нарийвчилсан төлөвлөгөө байна.

Уг төлөвлөгөөг оюутан нь удирдагч багшийн зөвлөгөөгөөр дадлагын ажил эхлэхэд гаргана. Гүйцэтгэх ажлуудын жагсаалтыг хугацааны хамтаар оруулж, гүйцэтгэлийг удирдагч багшаар баталгаажуулсан байх шаардлагатай.

Дадлагын ажлын хураангуй нь тухайн ажлын талаар бүрэн мэдээлэл өгч чадахуйц агуулга бүхий байвал зохино. Үүнд:

- дадлага хийсэн байгууллагын нэр;
- үйл ажиллагааны чиглэл;
- гүйцэтгэх хугацаа;
- дадлагын ажлын зорилго, шийдвэрлэх асуудлууд;
- ашигласан аргачлал, технологи зэргийг оруулна.

Дадлагын тайланд судалсан болсон гүйцэтгэсэн ажлууд, дадлагын ажлын хүрээнд тавигдсан асуудлыг шийдвэрлэсэн байдал, холбогдох шинжилгээ, сонгосон арга технологи,

асуудлыг шийдвэрлэхэд гарсан бэрхшээл зэргийг дэлгэрэнгүй оруулна.

Дадлагын ажлын тодорхойлолт-дадлагын ажил хийсэн байгууллага, удирдагчаас оюутны дадлагын ажлын үр дүнг тодорхойлсон байх бөгөөд гарын үсэг, тамгаар баталгаажуулсан байх шаардлагатай.

Тодорхойлолт нь оюутны ажлын үнэлгээний нэг хэсэг учраас 1-2 хуудаснаас хэтрэхгүй товч бөгөөд тодорхой, утга агуулга сайтай, үнэлгээтэй байвал зохино.

Үйлдвэрлэлийн дадлагын үед дараах чигл элүүдэд анхаарал төвлөрүүлж ажиллах ба тайланд дэлгэрэнгүй тусгана. Үүнд:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн дамжлагын дараалал, үйл ажиллагаа, мөрдөж байгаа горим
- Технологийн тооцоо хийх арга
- Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар , эрүүл ахуйн үзүүлэлтэд хяналт тавих үйл ажиллагаа, шинжилгээний арга зүй
- Түүхий эд бэлэн бүтээгдэхүүний хадгалалтын горим, нөхцөл, түүнийг хянах арга
- Тоног төхөөрөмжийн бүт эц, ажиллагаа, хяналт тавих арга
- Ажлын байр болон тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ ариутгал хийх журам
- Чанарын хяналтын системийн бүтэц, зохион байгуулалт

Төгсөлтийн өмнөх дадлагын явцад дараах чиглэлээр судалгаа хийж боловсруулах ба үр дүнг дадлагын тайланд оруулна. Үүнд:

- Өөрийн судалж буй салбарын бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа

- Түүхий эдийн судалгаа
- Технологийн дэвшил, эрүүл ахуйн хяналт
- Тоног төхөөрөмжийн судалгаа
- Бүтээгдэхүүний өртөг, зардлын судалгаа
- Үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалт, барилга байгууламжинд тавих эрүүл ахуйн шаардлага, барилгын зургийн стандарт, төсөв норматив, зардал тооцох аргын тухай

Зах зээлийн судалгаа

Тухайн үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх байр суурь, ололттой болон сул талууд, саад бэрхшээл болон боломжуудыг тодорхойлж гаргана. Хэрэглэгчдийн дунд санал асуулга явуулах, өрсөлдөгчийн судалгаа хийх замаар үйлдвэр байгуулах үндэслэл, бүтээгдэхүүний нэр төрлийн сонголтыг хийнэ.

Түүхий эд нь үйлдвэрийн тасралтгүй жигд ажиллагааг хангах гол хүчин зүйл нь түүхий эдийн нөөц байдаг. Тиймээс түүхий эдийн хангамж, хүрэлцээ, нөөц, татан авалт, хадгалалт зэрэг асуудлуудыг хэрхэн шийдэх талаар дэлгэрэнгүй судалсан байна.

Хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийн үйлдвэрт хийсэн дадлагын үр дүнгээс жишээ болгоё:

Түүхий эдийн судалгаа

Үйлдвэрийн үндсэн түүхий эд болох хошуу тариаг Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Айгар” ХХК болон Төв аймгийн Баянчандмань сумын “Мон тариалал” ХХК-уудтай гэрээ байгуулж, өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэж нийлүүлэх бүрэн боломжтой. 2022 оны хошуу тарианы ургац хураалтын дүн Дархан-Уул аймагт 2,6 тн, Төв аймагт 1,9 тн, Сэлэнгэ аймагт 0,6 тн байна.



Судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд хошуу тарианы тариалалт болон ургац хураалт жил бүр нэмэгдэж байгаа нь үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах, нөөц хангамж сайжрах хандлага байна.

Хэрэглэгчийн судалгаа

Хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг ОХУ-ын “Алейкзернопродукт”, “Ключевской элеватор” компанаас “Алейка Импекс”, “АГЬ” ХХК-ууд импортолж, бүтээгдэхүүнийг савлаж борлуулдаг. Дээрхи импортын бүтээгдэхүүний хэрэгцээний судалгааг хийлээ. Судалгаанд нийт 16-50 насны 50 хүн оролцсон болно.

Хэрэглэгчид бидний судалгааны асуултад хэрхэн хариулсан байдлыг доор харуулав.

Санал асуулгын асуулт, дүгнэлт

1. Та хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг хэрэглэдэг үү?



Судалгаанаас үзэхэд манай хэрэглэгчид хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг сонирхон хэрэглэж байгаа нь харагдаж байгаа бөгөөд хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг бүх насны хүмүүс хоол хүнсэндээ хэрэглэхэд тохиромжтой бөгөөд сувиллын өргөн хэрэглээний бүтээгдэхүүний нэг юм.

2. Та ямар учраас дээрхи бүтээгдэхүүнийг хэрэглэдэг вэ?



Судалгаанаас үзэхэд хэрэглэгчид тус бүтээгдэхүүнийг зохицуулах үйлчлэл талаас нь ач холбогдол өгч хэрэглэдэг нь харагдаж байна. Тус бүтээгдэхүүн нь бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад нийлмэл нүүрс усны агууламж өндөр бөгөөд тэр дундаа уусамхай эслэг нь цусан дахь холестерины түвшинг бууруулах, зүрх судасны өвчлөлийн эрсдэлийг бууруулах

давуу талтай бөгөөд чихрийн шижин өвчинтэй хүмүүс хэрэглэхэд тохиромжтой. Мөн уургийн эх үүсвэр болох төдийгүй ханаагүй тосны хүчил, В-ийн төрлийн аминдэм, исэлдэлтийн эсрэг үйлчилгээтэй Е аминдэм, эрдэс бодисуудыг зохистой хэмжээгээр агуулдаг зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүнд хамаарагддаг.

3. Та дээрхи бүтээгдэхүүнийг ямар үед хэрэглэдэг вэ?



Судалгаанаас үзэхэд манай хэрэглэгчид тус бүтээгдэхүүнийг өглөөний цайндаа түлхүү хэрэглэдэг нь харагдаж байна. Хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг өглөөний цайндаа хэрэглэснээр биеийн хүч, чадлыг нэмэгдүүлэх, арьсны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, бодисын солилцоог сэргээн тэнхрүүлэх, мэдрэлийн үйл ажиллагааг сайжруулах, бие организмд шингэц сайтайгаас гадна цусны холестериныг бууруулахад дэмжлэг үзүүлдэг хүнсний бүтээгдэхүүн юм.

4. Та хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг ямар бүтээгдэхүүнтэй хамт хэрэглэхийг илүүд үздэг вэ?



Үүнээс үзэхэд манай хэрэглэгчид хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг хатаасан жимстэй хэрэглэх хандлага давамгайлж байгаа ч бусад бүтээгдэхүүнтэй бас хэрэглэх хандлага ажиглагдлаа. Тухайн бүтээгдэхүүнийг хатаасан жимстэй хамт хэрэглэх нь эрүүл мэндэд тустай.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад хошуу тарианы хавтгайлсан бэлдмэл хэрэглэгчдийн дунд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүний нэг болох нь харагдаж байна. Худалдан авагчид тухайн бүтээгдэхүүний амт, өнгө үзэмж зэргийг харгалзах бус бие организмд шингэх байдал, ач тустай шинж чанарыг илүүд үзэж хэрэглэдэг нь судалгаанаас харагдаж байна.

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл: Тухайн хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг хэрэглэгчид өдөр тутам хоол хүнсэндээ хэрэглэж, ямарваа нэгэн өвчнөөр өвчилсний дараа бус өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд илүүтэй анхаарч хэрэглэдэг болох нь тодорхой байна. Тиймээс уг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна гэж дүгнэв.

Өрсөлдөгчийн судалгаа, үйлдвэрийн SWOT шинжилгээ

Хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг ОХУ-ын “Алейкзернопродукт”, “Ключевской элеватор” компаны

хавтгайлсан бэлдмэлийг “Алейка Импекс”, “АГЬ” ХХК-ууд импортоор задгайгаар орж ирдэг бүтээгдэхүүнийг савлаж борлуулдаг.

Хүснэгт 1

Хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийг импортлогч компани

№	Импортлогч компани	Хүчин чадал, жил/тн	Нийлүүлсэн бүтээгдэхүүн, тн		
			2020 он	2021 он	2022 он
1	“Алейка Им-пекс” ХХК	10,7	7,9	8,4	10,7
2	“АГЬ”ХХК	8,5	-	-	8,5
	Нийт	19,2	7,9	8,4	19,2

Үйлдвэрийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
➢ Шинэ нэр төрлийн эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн ➢ Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх ➢ Олон төрлийн нүүрс ус, ууараг, амин хүчил, аминдэм, эрдэс бодис, ханаагүй тосны хүчил зохистой хэмжээгээр агуулсан бүтээгдэхүүн ➢ Зохицуулах үйлчилгээтэй,	➢ Бүтээгдэхүүний нэр төрөл цөөн ➢ Найдвартай бэлтгэн нийлүүлэгч дутагдалтай ➢ Түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдээс хамааралтай ➢ Мэргэжсэн боловсон хүчин дутмаг

сувиллын бүтээгдэхүүн ➢ Үндэсний үйлдвэрлэгч	
Боломж ➢ Үндэсний “Брэнд” бүтээгдэхүүн бий болгох боломжтой ➢ Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжтой ➢ Түүхий эдийн тариалалт нэмэгдэж байгаа ➢ Импортын бүтээгдэхүүний зах зээлийг эзлэх боломжтой ➢ Учирч болох аюул заналаас сэргийлэхийн тулд даатгалд хамрагдах ба мэргэжлийн байгуулагуудтай нягт харилцаатай ажиллах ➢ Засгийн газрын хөтөлбөрт хамрагдаж санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх ➢ Жижиг дунд үйлдвэр дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжиж байгаа	Аюул ➢ Шинэ бүтээгдэхүүн учир хэрэглэгчид бүтээгдэхүүний онцлог давуу чанарыг төдийлөн сайн мэдэхгүй ➢ Улирлын байдлаас хамааралтай ган зуд зэрэг байгаль цаг уурийн эрсдэл болж түүхий эдийн хангамж буурч болзошгүй ➢ Дотоодын хэрэгцээ бүрэн хангагдвал өрсөлдөөн ширүүсч, маркетингийн зардал өсөх, үнэ буурах, засгийн газрын дэмжлэг зогсох аюултай ➢ Орчин үеийн технологийн шаардлагад нийцээгүй тоног төхөөрөмж нийлүүлэх магадлалтай

Технологийн дэвшил

Үйлдвэрлэлийн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний нэр төрөл, шинж чанар түүнийг тодорхойлох аргууд, технологийн үйл ажиллагааны схем, дэс дараалал, түүнд мөрдөх горим, жор

орцын тооцоо, технологийн хяналтын арга хэлбэрүүд, чанарын хяналтын системийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга зүй, ач холбогдол

Үйлдвэрлэлийн процесст шин э техник технологи н эвтрүүлж байгаа байдал , шинэчлэн сайжруулах арга зам, судалгаа шинжилгээ, сорилт туршилт явуулах, зохион бүтээх ажлын явц хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар судлана.

Орчин үеийн шинэ, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ямар боломж байгааг судалсан байна. /эрчим хүч хэмнэсэн, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн, овор багатай, бүтээмж өндөртэй…г.м/

Жишээ:

Хошуу тариаг боловсруулах технологийн онцлог:

- Хошуу тариаг бусад үр тариатай харьцуулахад хальсан давхарга ихтэй бөгөөд тухайн бүтээгдэхүүний гарц, чанар, нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах энергийн хэмжээ ихтэй зэрэг нь тухайн технологийн онцлог болно.
- Хошуу тарианы хавтгайлсан бэлдмэлийн тариа цэвэрлэх ажиллагаа нь бусад үр тариатай ижил аргаар явагдана.
- Цэвэрлэсэн хошуу тариаг боловсруулсны дараа 2 булт төхөөрөмж ашиглан хавтгайлсан бэлдмэл болгон үйлдвэрлэдэг.

Хошуу тариаг боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн үйл ажиллагаа нь дараах үндсэн гурван дамжлага, үе шатаас бүрдэнэ.

- Тариаг хүлээн авах, чанараар нь ангилан хадгалалтанд шилжүүлэх
- Тарианы хольцыг цэвэрлэх, ус дулаанаар боловсруулах

❖ Бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ангилан савлах



Зураг 1. Хошуу тарианы хавтгайлсан бэлдмэл үйлдвэрлэх технологийн бүдүүвч

"Хүнсний хошуу тариа MNS 5272:2003" үндэсний стандартын шаардлага хангасан тариаг сорт, чийглэг, гаднын хольцын хэмжээгээр ангилан хүлээн авч 10^{0}С-ээс дээшгүй температуртай, 60%-иас дээшгүй агаарын харьцангуй чийглэгтэй орчинд задгайгаар эсвэл уутанд хэсэгчлэн савлаж хадгална.

Тоног төхөөрөмжийн судалгаа

Материаллаг нөөц, түүний хангамж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүчин чадал, тэдгээрийн х эрэгцээг тооцоолох аргууд, ашиглалт, үйлдвэрлэлийн хүчин чадлын тооцоог оруулна.

Тоног төхөөрөмжийн сонголтыг хийхдээ олон талын харьцуулсан судалгаа явуулах хэрэгтэй /үнэ, бүтээмж, овор хэмжээ, зай талбай, цахилгаан зарцуулалт, материал, сэлбэг хэрэгслийн олдоц…/

Бүтээгдэхүүний өртөг, зардал

Бүтээгдэхүүний зардлыг тооцох арга, өөрийн өртөгт хамаарах зардал, нөлөөлөх хүчин зүйл, үнэ тогтоох аргууд, ашгийг нэмэгдүүлэх боломж, нэгж бүтээгдэхүүний зардлын тооцоо, үйлдвэрийн хүчин чадал, хөрөнгө оруулалт, цалингийн сан, үндсэн хөрөнгийн элэгдэл, үр ашгийн тооцоо, ашгийн хуваарилалт, зээл төлбөрийн тооцоо, үр ашгийн нэгдсэн үзүүлэлтүүдийг тайланд тусгана.

Үйлдвэрийн барилга байгууламжинд тавигдах шаардлага

Барилгын бүтцийн онцлог, үйлдвэрлэлийн технологийн урсгалын чиг, усан хангамж, цэвэрлэгээ ариутгал хийх журам, түүний мөрдөлтийн тухай дэлгэрэнгүй оруулна.

Хоолны мэргэжлийн дадлагын хувьд нэгж хоолны технологийн карт, илчлэгийн тооцоог хэрхэн хийх тухай тусгана.

ГУРАВ. ДАДЛАГЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Танилцах дадлагаас бусад дадлагын дараа тайлан бичиж хамгаална.

Дадлагын тайлан нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Нүүр хуудас
- Гарчиг
- Оршил
- Онолын хэсэг
- Судалгааны хэсэг
- Дүгнэлт
- Ашигласан материал
- Хавсралт

Нүүр хуудас-сургууль, тэнхимийн нэр, удирдагч багшийн нэр, оюутны нэр, гарын үсэг, он сар гэсэн мэдээллүүдийг агуулна.

Гарчиг-ажлын бүлгүүдийн нэр, хуудасны дугаарыг харуулна.

Оршил хэсэг-дадлагын ажлын зорилго, тухайн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, технологийн дэвшил гарсан үр дүн, ач холбогдлыг агуулсан байна.

Онолын эхний хэсэгт тухайн үйлдвэрийн танилцуулга, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний нэр төрөл, онцлогийг оруулах ба дараагийн хэсэгт уг салбар үйлдвэрлэлийн талаарх товч онол, технологи, тэдгээрийн практик хэрэглээний ач холбогдлыг багтаана.

Судалгааны хэсэгт дадлагын хугацаанд өөрийн боловсруулсан судалгаа шинжилгээ, ажиглалт, туршилтын загвар, үр дүнг дэлгэрэнгүй бичиж, зураг бүдүүвч, график, хүснэгт ашиглан тайлбар хийсэн байна. Мөн судалгааг хэрхэн,

яаж явуулсан, ямар арга зүй хэрэглэсэн, туршилтыг ямар нөхцөлд хийсэн, үр дүнгийн харьцуулалт зэргийг багтаана.

Тухайн үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалтын онцлог, барилга байгууламжинд тавих эрүүл ахуйн шаардлага хангагдаж байгаа эсэх, давуу сул тал болон зөрчил доголдлыг арилгах талаар санал дүгнэлт хийсэн байна.

Дүгнэлтийн хэсэгт дадлагын зорилго хэрхэн хангагдсан, олж мэдсэн мэдлэг чадвартаа тулгуурлан цаашид ажиллаж, суралцахад анхаарах өөрийн санал дүгнэлтийг бичнэ. Өөрийн судалгааны үр дүнг тайлбарлаж, түүндээ дүн шинжилгээ хийсэн байна. Тэдгээр нь ямар нэгэн онол, зарчимд нийцэж буй эсвэл эсрэг байгаа эсэхийг тайлбарлаж, баталгаа, үндэслэлийг гаргаж, анхны дэвшүүлсэн таамаглалтай нийцсэн эсэх, мөн судалгааны үр дүн юунд хэрэгтэй болох, хэрэгжүүлснээр юу өөрчлөгдөх талаар дүгнэнэ.

Зөвлөмж-тухайн судалгааг хийхэд хүргэсэн шийдвэрлэвэл зохих асуудлыг шийдэхийн тулд цаашид ямар арга хэмжээ авч хэрэгжүүлбэл зохих талаар өөрийн санал, зөвлөмжийг боловсруулан бичиж болно.

Ашигласан материалыг зохиогчийн нэрний эхний үсгийн дэс дараалаар жагсаан бичнэ.

Хавсралт хэсэгт график, тооцоо хийх арга зүй, хүснэгт, бүдүүвч, зураг схем, дадлагын гурвалсан гэрээ зэргийг оруулна.

ДӨРӨВ. ТАЙЛАН ХАМГААЛАЛТ

Дадлагын тайлан хамгаалахдаа танилцуулгыг “Microsoft Power Point” програм дээр хийнэ. Танилцуулга бэлтгэхдээ дараах зүйлд анхаарвал зохино. Үүнд:

- Текст болон график дүрслэлийг хослуулан ашиглах
- Агуулгыг ойлгомжтой гаргахын үүднээс нэг слайд дээр 3-аас олон асуудлыг оруулахаас зайлсхийх
- Агуулга дахь онцлог зүйлийг тодотгож өгөх
- Мультимедиа хэрэгслэлүүдийг ашиглах